

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХДАЛДААНЫ ХУРЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 14-ний өдөр

Дугаар 02/22

Улаанбаатар хот

Ногдол ашгийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 46.6 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, Компанийн дүрмийн 8.В-ийн 8.13 дахь заалтуудыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Монноос” хувьцаат компани нь 2021 онд үйлдвэрийн тоног төхөөрөмжийн насжилт өндөр, хуучирснаас шалтгаалан компанийн дүрэмд заасан үндсэн үйл ажиллагааг явуулж чадаагүй, цар тахлын улмаас ихэнх түрээслэгч түрээсийн гэрээгээ цуцалж, орлого буурснаас алдагдалтай ажилласан тул 2021 оны санхүүгийн үзүүлэлтүүдийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны дүнгээр ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан шийдвэрийн эдийн засгийн болон хуулийн үндэслэлийг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч П.Оюунбаярт даалгасугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮН



- П.ОЮУНБАЯР
- С.АЛИМАА
- Ц.ЦЭНГЭЛБАЯР
- С.МӨНХЖАРГАЛ
- П.ОЮУНБАЯР
- Х.ЭРДЭНЭБАЯР
- Х.ОЮУНГЭРЭЛ
- Л.БҮРЭНТЭГШ
- И.СЭР-ОД